



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/136

Мандалговь

Газар албадан чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх заалт, 56 дугаар зүйлийн 56.5 дахь заалт, 57 дугаар зүйлийн 57.4 дэх заалт, 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайнцагаан сумын нутаг дэвсгэрт зохих зөвшөөрөлгүй дур мэдэн өөрийн өмчлөлийн газрын хэмжээг сунгасан, дугуй засвар, автомашины гараж барьсан мөн амбаар, контейнер, ёмкость байрлуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газрын байршлыг 1 дүгээр хавсралтаар, зарцуулагдах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус батласугай.

2. Хавсралтад заасан байршлуудад газар чөлөөлөх ажлыг зохион байгуулахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Цагдаагийн газар (Б.Мөнхбат), Хот тохижуулах газар (Д.Очбадрах)-т тус тус үүрэг болгосугай.

3. Газар чөлөөлөхтэй холбогдон гарах зардлыг Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Энхтайван) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100322